



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2020/5/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд  
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424

Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345

Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил Үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал .....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.07.24 № 2/д.20

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

005020180



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.1. Оршил

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Б.Наранбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 01 дүгээр сарын 29-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр ирүүлж, аудит хийлгэх тухай албан бичгийг 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 2/116 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Засаг даргаас хуулиар тогтоосон бүрэн эрх, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад ажлын албыг удирдлага чиг үүргээр хангаж, засаг даргыг цаг үеэ олсон мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангаж, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх, төрийн хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлж сурталчлах, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, шударга хүргэх”-д оршино.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг үнэлгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
2. Төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагын түншлэлийг сайжруулан орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах
4. Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулан төрийн байгууллага, багийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг тогтмол зохион байгуулах.
5. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” , “Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил”-ийн ажлыг төлөвлөгөөтэй хэрэгжүүлж, зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 42 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 4.10, цалингийн Payroll программ хангамж ашигладаг байна.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 39 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 22 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн, зардлын дүн тэрбум төгрөгөөс дээш дүнтэй тул материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 2 хувиар буюу 5600.3 мянган төгрөгөөр тооцож баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 8359.5 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 2759.2 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг байгууллагын 2019 он 03 дугаар улирлын санхүүгийн тайланг татсантай холбоотой байна.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 157967.7 мянган төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-
АВЛАГА	-	-	-
БАРАА МАТЕРИАЛ	33,849.25	19,281.02	(14,568.24)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,599,904.21	1,757,748.07	157,843.86
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(563,602.94)	(548,910.87)	14,692.07
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,070,150.52	1,228,118.22	157,967.69
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	1,070,150.52	1,228,118.22	157,967.69
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,070,150.52	1,228,118.22	157,967.69

Тус байгууллага Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлж, авлага, өглөггүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 14568.2 мянган төгрөгөөр буурч, 19281.0 мянга, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 157843.8 мянган төгрөгөөр өсч оны эцэст 1757748.0 мянган төгрөг болсон нь тайлант онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн үндсэн хөрөнгийг орлогод авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1228118.2 мянган төгрөг болж 157967.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 6 арга хэмжээний зардалд зориулан 313568.5 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, орон нутгийн төсвөөс санхүүжилтийг бүрэн олгожээ.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлогоор 600.0 мянган төгрөг оруулах төлөвлөгөө өгснийг бүрэн оруулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд тендерийн баримт бичгийн үнийн андуурч орсон 60.0 мянган төгрөгийн орлого орсныг гүйлгээ хийсэн хүнд нь буцаан шилжүүлснээс өөр гүйлгээ байхгүй байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 39 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 22 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 39 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 32 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /сая.төг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	6.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	1.1	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
Дүн		5	7.7	

Аудитаар нийт 7731.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1132.0 мянган төгрөгийн 1 алдаанд албан шаардлага өгч, 6599.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгав.

Сумын цэвэр бохир усны 700.0 мянга, орон нутгийн судлах төвийн 1000.0 мянга, цэнгэлдэх хүрээлэнгийн 1000.0 мянга, Соёлын төвийн 600.0 мянга, ЗДТГ-ын 1000.0 мянга, нийт 4000.0 мянган төгрөгийн зураг төсвийн үнийг сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлснийг ОНХС-ийн хөрөнгөд бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгэхээр байхад сумын Засаг даргын 2019.10.03-ний өдрийн А/87 тоот захирамжаар сумын ЗДТГ-ын бараа материалд орлогоор бүртгэсэн, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсийг хөрөнгийн өртөгт нэмж тооцоогүй байсан зэрэг зөрчлийг аудитын тайланд залруулав.



### 2.11.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.11.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Лувсанданзанжанцангийн мэлмий гийсний 380 жилийн ойн зардалд 1032.0 мянган төгрөг олгох тухай Баацагаан сумын ЗДТГ-ын даргын А/15 тоот, байгууллагын ажилтан П.Мөнхжаргалд 100.0 мянган төгрөгийн тэтгэмж олгох тухай Б/10 тоот тушаалыг байгууллагын цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, ... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

### 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Ахуйн үйлчилгээний барилга дотор үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжээс авч байгаа түрээсийн орлого бүрэн орсон эсэх, уурын зуухны газрын эзэмшил, хөрөнгийн асуудлыг тодруулж үзэх шаардлагатай.

### 2.13. Шилэн дансны мэдээлэл

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудаст оруулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	11		-
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	95	1	
	Нийт	27	151	150	1	-

### 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөвлөмж өгөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.



## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### “Зөрчилгүй” дүгнэлт

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

#### 3.1.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд гуляш, ногоотой шөл зэргийг бүртгэсэн.

Байгууллагын бүртгэлд байгаа 425.8 мянган төгрөгийн малыг статистикийн А данс, тоогоор албажуулаагүй, олон залгуур, түгжээ, онцгой байдлын хувцас зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанаргүй хөрөнгийг үндсэн хөрөнгөд, хурлын сандал бараа материалд бүртгэсэн байна. Бараа материал дансанд нягтлан бодох бүртгэлийн хураамж, самбарын зураг, ХҮОАТатвар, цэцэг зэрэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС 12, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан зааврын 4.15 дахь заалтыг зөрчсөн байна.

#### 3.1.2 Эрсдэл:

Бараа материал дансанд тавих дотоод хяналт алдагдах

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Арга хэмжээний зардлыг олгохдоо бараа материалын дансанд бүртгэлгүй, өглөгийг дансаар дамжуулан зардлаар тайлагнаж байх

#### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

### 3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

#### 3.2.1 Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөөр 200.0 мянган төгрөгийн архивын программ, 365.0 мянган төгрөгийн санхүүгийн программ, 50.0 мянган төгрөгийн төрийн сангийн, 385.0 мянган төгрөгийн төрийн сангийн программ бүртгэлтэй байгаагаас 2011 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 200.0 мянган төгрөгийн архивын программ ашиглалтгүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5 дахь "Тооллогын

комисс, түүний үүргийг "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон ... бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн архивын цахим программыг цаашид ашиглах боломжтой эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

## 3.3 Зардлын данстай холбоотой асуудал

### 3.3.1 Илрүүлэлт:

Байгууллагын архив, бичиг хэргийн ажилтан нууц хамгаалах ажилтнаар томилоогүй байхад 10 хувийн нэмэгдэл олгосон байна. Ажиллагсдад байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулахдаа үндсэн цалинг бууруулаагүй, сахилгын шийтгэлийн бичилтийг буруу хийснээс цалингийн зардал санхүүгийн тайланд 813.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 1.2, 2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

### 3.3.2 Эрсдэл:

Батлагдсан орон тоогүй атлаа хавсран ажилласан нэмэгдэл цалин олгосон байх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Архив, бичиг хэргийн ажилтанд олгож байгаа нууц хамгаалах ажилтны нэмэгдлийг зогсоох, сахилгын шийтгэл ногдуулах нягтлан бодох бүртгэлийн бичилтийг зөв бүртгэж, цалингийн зардлыг зөв тайлагнах.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

## 3.4. Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

### 3.4.1. Илрүүлэлт

Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй нийтийн ахуйн үйлчилгээний барилгыг түрээсээр эзэмшүүлдэг ба түрээсийн гэрээг удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй. Тус байгууллагын бүртгэлд 1782.0 мянган төгрөгийн төвлөрсөн уурын зуухны газар бүртгэлтэй ба тус газарт "Могойн хөндий" ХХК уурын зуух барьсан байна. Эдгээр хөрөнгүүдийг түрээслүүлсний орлогоор тайлант онд орлого бүртгэгдээгүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна аймгийн ИТХ-ын 2018 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 43 тоот тогтоолоор баталсан түрээсийн төлбөрийн жишиг үнийг баримтлан түрээсийн гэрээг байгуулж, түрээсийн орлогыг төсөвт тухай бүр бүрэн төвлөрүүлж, газрын маргаантай асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлэх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**

**1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>33,849,254.50</b>	<b>19,281,018.00</b>
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	33,849,254.50	19,281,018.00
Хангамжийн материал	30,932,254.50	18,855,218.00
Бичиг хэргийн материал	5,611,205.00	5,181,055.00
Аж ахуйн материал	19,121,049.50	13,674,163.00
Хүнсний материал	150,000.00	00.00
Бусад хангамжийн материал	6,050,000.00	00.00
Мал амьтад	2,917,000.00	425,800.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,036,301,270.35</b>	<b>1,208,837,197.96</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,036,301,270.35	1,208,837,197.96
<b>Биет хөрөнгө</b>	967,685,270.35	1,140,221,197.96
Барилга, байгууламж, орон сууц	1,063,774,896.67	1,108,630,096.67
Хуримтлагдсан элэгдэл	-235,112,755.03	-223,073,387.55
Авто-тээврийн хэрэгсэл	131,508,644.00	180,699,800.00
Хуримтлагдсан элэгдэл	-103,268,137.56	-96,575,253.67
Машин тоног төхөөрөмж (компьютер)	232,501,251.44	230,348,849.64
Хуримтлагдсан элэгдэл	-154,107,299.00	-156,450,654.89
Тавилга, аж ахуйн эд хогшил	35,949,518.71	47,473,420.00
Хуримтлагдсан элэгдэл	-20,471,033.65	-19,309,906.65
Зам, гүүрийн байгууламж	746,403.36	746,403.36
Хуримтлагдсан элэгдэл	00.00	-62,200.32
Бусад үндсэн хөрөнгө	65,807,500.00	120,233,500.00
Хуримтлагдсан элэгдэл	-49,643,718.59	-52,439,468.63
<b>Биет бус хөрөнгө</b>	68,616,000.00	68,616,000.00
Програм хангамж	1,000,000.00	1,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-1,000,000.00	-1,000,000.00
Бусад биет бус хөрөнгө	68,616,000.00	68,616,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,070,150,524.85</b>	<b>1,228,118,215.96</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,070,150,524.85</b>	<b>1,228,118,215.96</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,070,150,524.85	1,228,118,215.96
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	648,743,631.82	648,743,631.82
Өмч: - төрийн	648,743,631.82	648,743,631.82
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-10,254,736.16	147,712,954.95
Өмнөх үеийн үр дүн	-10,254,736.16	-10,254,736.16
Тайлант үеийн үр дүн	00.00	157,967,691.11
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431,661,629.19	431,661,629.19
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,070,150,524.85</b>	<b>1,228,118,215.96</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>362,284,079.00</b>	<b>575,944,900.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,213,050.00</b>	<b>256,619,800.00</b>
Нийтлэг татварын бус орлого	24,213,050.00	256,619,800.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	24,213,050.00	256,619,800.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	507,500.00	600,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,705,550.00	256,019,800.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>338,071,029.00</b>	<b>319,325,100.00</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,697,736.00	60,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,697,736.00	00.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	60,000.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>335,346,300.00</b>	<b>319,265,100.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	335,346,300.00	319,265,100.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,993.00	00.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	26,993.00	00.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>386,202,778.39</b>	<b>412,337,559.20</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>386,202,778.39</b>	<b>412,337,559.20</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>351,702,751.39</b>	<b>396,823,264.20</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,775,861.00	208,947,034.00
Үндсэн цалин	194,775,861.00	208,947,034.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,158,855.00</b>	<b>26,376,873.00</b>
Тэтгэврийн даатгал	14,682,555.00	17,989,644.00
Тэтгэмжийн даатгал	1,872,675.00	2,097,605.00
ҮОМШӨ-ний даатгал	1,494,299.00	1,678,083.00
Ажилгүйдлийн даатгал	373,575.00	416,331.00
Эрүүл мэндийн даатгал	3,735,751.00	4,195,210.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,166,145.00</b>	<b>17,592,738.00</b>
Гэрэл, цахилгаан	2,147,327.00	3,648,738.00
Түлш, халаалт	14,018,818.00	13,944,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,483,626.00</b>	<b>38,975,780.00</b>
Бичиг хэрэг	6,308,240.00	3,409,550.00
Тээвэр, шатахуун	21,632,386.00	19,201,900.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	171,000.00	689,400.00
Ном, хэвлэл	37,000.00	00.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	299,130.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,335,000.00	721,500.00
Бараа материал акталсны зардал	00.00	14,654,300.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>2,187,086.50</b>
Урсгал засвар	00.00	2,187,086.50
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,123,500.00</b>	<b>9,616,800.00</b>
Гадаад албан томилолт	00.00	1,000,000.00
Дотоод албан томилолт	4,123,500.00	4,548,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	4,068,800.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,362,415.00</b>	<b>7,809,730.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,191,500.00	3,228,020.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	299,500.00
Даатгалын үйлчилгээ	374,115.00	395,410.00
Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	202,800.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,800.00	120,000.00

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,632,349.39</b>	<b>85,317,222.70</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,516,500.00	3,999,800.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	100,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,115,849.39	81,217,422.70
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,500,027.00</b>	<b>15,514,295.00</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,922,200.00</b>	<b>00.00</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,922,200.00	00.00
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,026,656.00</b>	<b>14,166,900.00</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	26,993.00	00.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,999,663.00	00.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	14,166,900.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>28,551,171.00</b>	<b>1,347,395.00</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	28,551,171.00	1,347,395.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-23,918,699.39</b>	<b>163,607,340.80</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>10,645,651.53</b>	<b>5,639,649.69</b>
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	5,639,649.69
Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	10,645,651.53	00.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-10,645,651.53</b>	<b>-5,639,649.69</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-34,564,350.92</b>	<b>157,967,691.11</b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>338,578,529.00</b>	<b>319,925,100.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>507,500.00</b>	<b>600,000.00</b>
Нийтлэг татварын бус орлого	507,500.00	600,000.00
<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>507,500.00</b>	<b>600,000.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	507,500.00	600,000.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>338,071,029.00</b>	<b>319,325,100.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,697,736.00</b>	<b>60,000.00</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,697,736.00	00.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	60,000.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>335,346,300.00</b>	<b>319,265,100.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	335,346,300.00	319,265,100.00
<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>26,993.00</b>	<b>00.00</b>
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	26,993.00	00.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>338,578,529.00</b>	<b>316,125,100.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>338,578,529.00</b>	<b>316,125,100.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>288,536,802.00</b>	<b>300,610,805.00</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>194,775,864.00</b>	<b>208,947,034.00</b>
Үндсэн цалин	165,869,252.00	182,759,834.00
Нэмэгдэл	24,315,611.00	26,187,200.00
Гэрээт ажлын хөлс	4,591,001.00	00.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,158,852.00</b>	<b>26,376,873.00</b>

**Баацагаан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Тэтгэврийн даатгал	14,639,878.00	17,917,457.00
Тэтгэмжийн даатгал	1,924,468.00	2,104,396.00
ҮОМШӨ-ний даатгал	1,466,840.00	1,683,195.00
Ажилгүйдлийн даатгал	374,341.00	419,072.00
Эрүүл мэндийн даатгал	3,753,325.00	4,252,753.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,166,145.00</b>	<b>17,592,738.00</b>
Гэрэл, цахилгаан	2,172,005.00	3,648,738.00
Түлш, халаалт	13,994,140.00	13,944,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,145,786.00</b>	<b>23,762,330.00</b>
Бичиг хэрэг	3,111,050.00	2,944,400.00
Тээвэр, шатахуун	17,970,736.00	19,229,900.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	391,500.00	689,400.00
Ном, хэвлэл	87,000.00	00.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	299,130.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	585,500.00	599,500.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,952,600.00</b>	<b>2,503,500.00</b>
Багаж, техник, хэрэгсэл	7,049,300.00	00.00
Урсгал засвар	4,903,300.00	2,503,500.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,123,500.00</b>	<b>9,518,800.00</b>
Гадаад албан томилолт	00.00	1,000,000.00
Дотоод албан томилолт	4,123,500.00	4,520,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	3,998,800.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,877,415.00</b>	<b>7,809,730.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	706,500.00	3,228,020.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	299,500.00
Даатгалын үйлчилгээ	374,115.00	395,410.00
Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	202,800.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,800.00	120,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,336,640.00</b>	<b>4,099,800.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	12,237,640.00	3,999,800.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	99,000.00	100,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,041,727.00</b>	<b>15,514,295.00</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>19,463,900.00</b>	<b>00.00</b>
Засгийн газрын дотоод шилжүүлэг	19,463,900.00	00.00
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,026,656.00</b>	<b>14,166,900.00</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	26,993.00	00.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,999,663.00	00.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	12,566,900.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,600,000.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>28,551,171.00</b>	<b>1,347,395.00</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	28,551,171.00	1,347,395.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>3,800,000.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>3,800,000.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>3,800,000.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>3,800,000.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,800,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-3,800,000.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>



#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	580,127,631.82	214,351,930.00	-89,202,105.73	705,277,456.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>580,127,631.82</b>	<b>214,351,930.00</b>	<b>-89,202,105.73</b>	<b>705,277,456.09</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,407,223.72	-13,407,223.72
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>648,743,631.82</b>	<b>431,661,629.19</b>	<b>-10,254,736.16</b>	<b>1,070,150,524.85</b>
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>648,743,631.82</b>	<b>431,661,629.19</b>	<b>-10,254,736.16</b>	<b>1,070,150,524.85</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>648,743,631.82</b>	<b>431,661,629.19</b>	<b>-10,254,736.16</b>	<b>1,070,150,524.85</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	157,967,691.11	157,967,691.11
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>648,743,631.82</b>	<b>431,661,629.19</b>	<b>147,712,954.95</b>	<b>1,228,118,215.96</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	338,642,300.00	307,304,379.00	319,865,100.00	318,517,705.00
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	338,642,300.00	307,304,379.00	319,865,100.00	318,517,705.00
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	291,007,200.00	285,840,816.00	305,683,100.00	304,350,805.00
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	194,849,000.00	194,775,864.00	209,257,472.00	208,947,034.00
Үндсэн цалин	164,573,900.00	16,586,925.00	183,070,272.00	182,759,834.00
Нэмэгдэл	25,714,000.00	24,315,611.00	26,187,200.00	26,187,200.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,672,600.00	22,158,852.00	26,421,628.00	26,376,873.00
Тэтгэврийн даатгал	16,833,600.00	14,639,878.00	17,960,128.00	17,917,457.00
Тэтгэмжийн даатгал	1,959,700.00	1,924,468.00	2,115,400.00	2,104,396.00
ҮОМШӨ-ний даатгал	1,567,800.00	1,466,840.00	1,692,300.00	1,683,195.00
Ажилгүйдлийн даатгал	392,000.00	374,341.00	423,100.00	419,072.00
Эрүүл мэндийн даатгал	3,919,500.00	3,753,325.00	4,230,700.00	4,252,753.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,281,200.00	16,166,145.00	17,597,500.00	17,592,738.00
Гэрэл, цахилгаан	2,207,100.00	2,172,005.00	3,653,400.00	3,648,738.00
Түлш, халаалт	14,074,100.00	13,994,140.00	13,944,100.00	13,944,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	230,380,700.00	20,168,050.00	23,774,900.00	23,762,330.00
Бичиг хэрэг	3,128,500.00	3,111,050.00	2,948,000.00	2,944,400.00
Тээвэр, шатахуун	15,993,300.00	15,993,000.00	19,229,900.00	19,229,900.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	569,000.00	391,500.00	697,000.00	689,400.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	300,000.00	299,130.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	590,200.00	585,500.00	600,000.00	599,500.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,971,700.00	11,952,600.00	6,305,000.00	6,303,500.00
Багаж, техник, хэрэгсэл	7,050,000.00	7,049,300.00	1,700,000.00	1,700,000.00
Урсгал засвар	00.00	00.00	4,605,000.00	4,603,500.00
<b>Томилолт, зочны зардал</b>	5,800,900.00	4,123,500.00	10,427,900.00	9,518,800.00
Гадаад албан томилолт	00.00	00.00	1,000,000.00	1,000,000.00
Дотоод албан томилолт	5,800,900.00	4,123,500.00	5,427,900.00	4,520,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	4,000,000.00	3,998,800.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,764,500.00	4,512,415.00	7,798,700.00	7,749,730.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	519,000.00	341,500.00	3,183,200.00	3,168,020.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	300,000.00	299,500.00
Даатгалын үйлчилгээ	400,000.00	374,115.00	400,000.00	395,410.00
Тээврийн хэрэгслийн татвар	231,500.00	200,000.00	231,500.00	202,800.00



**Баацагаан сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	32,800.00	120,000.00	120,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	3,564,000.00	3,564,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12100000.00</b>	<b>11983390.00</b>	<b>4100000.00</b>	<b>4099800.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	11,884,390.00	4,000,000.00	3,999,800.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	99,000.00	100,000.00	100,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47635100.00</b>	<b>21463563.00</b>	<b>14182000.00</b>	<b>14166900.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>1,999,663.00</b>	<b>14,182,000.00</b>	<b>14,166,900.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00	12,566,900.00	12,566,900.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	1,615,100.00	1,600,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>338,642,300.00</b>	<b>307,304,379.00</b>	<b>319,865,100.00</b>	<b>318,517,705.00</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>338,042,300.00</b>	<b>306,796,879.00</b>	<b>319,265,100.00</b>	<b>317,917,705.00</b>
Орон нутгийн төсвөөс	338,042,300.00	306,796,879.00	319,265,100.00	317,917,705.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>600,000.00</b>	<b>600,000.00</b>	<b>600,000.00</b>	<b>600,000.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	600,000.00	600,000.00	600,000.00
Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>
Удирдах ажилтан	10.00	10.00	10.00	10.00
Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	10.00	10.00
Үйлчлэх ажилтан	03.00	03.00	03.00	03.00
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	08.00	08.00	08.00	08.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	06.00	06.00
Улс төрийн албан хаагч (УТ)	09.00	09.00	09.00	09.00

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,697,736</b>	<b>60,000</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,697,736</b>	<b>60,000</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,697,736	60,000
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,977,736	-
Тээвэр, шатахуун	1,977,736	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	365,000	60,000
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	365,000	60,000
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	353,250	-
Бараа үйлчилгээний бусад зардал	353,250	-
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,750</b>	-
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,750	-
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,697,736</b>	<b>60,000</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,697,736</b>	<b>60,000</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,697,736	60,000
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР .....

**Б.ДОЛЖМАА**  
Огноо: 2020.02.27

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР .....

**А.ЦЭЭНЯМ**  
Огноо: 2020.02.27

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР .....

**Б.МӨНХБАТ**  
Огноо: 2020.02.27